



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 59

Мандалговь

Ашиглалтгүй байгаа эд хөрөнгийг
худалдах зөвшөөрөл олгох тухай

“Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 1.3.л, 20 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 77 дугаар зүйлийн 2.1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. 2017 оны 2-р улиралд зохион байгуулсан орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар ашиглалтгүй байгаа хавсралтад заасан дизель станцуудыг үнэ тогтоон дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Дизель станцуудын элэгдэл хорогдлыг тооцож зах зээлийн ханштай уялдуулан боломжит дээд үнээр дуудлагын худалдааны доод үнийг тогтоохыг сумын ИТХ-д зөвлөсүгэй.

3. Дуудлагын худалдааг 2017 оны 12 сарын 25-ны дотор зохион байгуулж, дуудлагын худалдаанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэхийг сумдын засаг дарга, ӨХБЗөвлөлүүдэд даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

8150140

//

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
10 сарын 18 өдрийн 59 тоот тогтоолын хавсралт



№	Сум	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ	Тоо	нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл
1	Адаацаг	01.01.01	20,288,625.00	2	40,577,250.00	40,577,250.00
2	Дэлгэрхангай	01.01.01	23,288,342.40	1	23,288,342.40	23,288,342.40
3	Баянжаргалан	00.01.01	27,135,000.00	2	54,270,000.00	44,998,875.00
4	Өндөршил	00.05.20	13,991,873.31	3	41,975,619.93	41,975,619.93
дүн				8	160,111,212.33	150,840,087.33